



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №02


2019 оны 1-р сарын 07-11

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 6 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 4(66%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1(17%) хумхаа, 1(17%) ям өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдээд байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Өвөрхангай, Орхон аймгаас галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 4 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 50%-иар бага байна. Эпидемиологийн 2-р долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлттэй байна.



Энэ долоо хоногт Орхон аймгаас галзуу өвчний эрсдэлд өртсөн 3 тохиолдол бүртгэгдсэн. 01 дүгээр сарын 05-ны өдөр 3 хүн Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хангал өртөө Хонгор овоо Алагийн даваанд өвөлжиж байгаа малчин “П”-ийн нохойнд уруулсан бөгөөд эмнэлэгт 01 дүгээр сарын 09-ны өдөр эмнэлэгт хандаж галзуугийн эсрэг вакцины эхний тунд хамрагдсан. Өвчтөнүүд БОЭТ-ийн мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлж байна. Одоогоор өвчтөнүүдийн биеийн байдал тогтвортой байна.

Эрсдэлд өртсөн сэжигтэй тохиолдлуудад галзуугийн эсрэг ийлдэсийг I/10-ны өдөр, вакцины II-р тунг I/11-ны өдөр аваад байна. Нохойг устгаж, дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Орхон аймгийн эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэй гэж дүгнэсэн. Тус хотын айлын 9 нохойг устгаж, хүн амд галзуу өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгаа хийгдсэн. Тус суманд 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон байна. Мөн гэрийн гадаа уяатай адуу руу дайрч уруул хэсэгт 3 соёо орсон шархтай. Адууг устгах арга хэмжээг 2019 оны 01 сарын 11-нд авахаар шийдвэрлэн уяатай ажиглалт хийж байна.

1.2 Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол:

Өвчтөн “Я” 32 настай, эрэгтэй. Япон улсын иргэн Монгол улсад Багануур дүүргийн боловсролын хэлтэст ажилладаг. Тайланд улсын Бангконг хотын Чиммайд 2018 оны 12-р сарын 26-наас 01-р сарын 03-ны өдрийн хооронд аялалаар явсан, энэ үед шумууланд хазуулсан.өгүүлэмжтэй. 01-р сарын 07-нд Монголд буцаж ирсэн ба энэ үед халуурч байсан. Өвчтөний гэр бүл ойр орчимд халуурсан ижил төстэй шинж тэмдэг илэрсэн хүн байхгүй. 01-р сарын 09-нд Интермед эмнэлэгт хандсан. Одоогоор өвчтөний биеийн байдал тогтвортой байна. Интермед эмнэлэгт 01-р сарын 10-ны 00:30 цагт ЗӨСҮТ-ийн дуудлагын баг очиж ажилласан. ЗӨСҮТ-ийн лабораторит бичил харах шинжилгээгээр хумхаа өвчний шимэгч харагдаагүй, хурдавчилсан сорил сөрөг гарсан. Молекул билологийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн байна.

1.3 Ям өвчний сэжигтэй тохиолдол:

Өвчтөн “Х” 1.8 настай, эрэгтэй. Төв аймгийн Угтаал Цайдам сумын Хушаатын Уушиг багт өвөө, эмээтэйгээ амьдардаг. Төв аймгийн Угтаал Цайдам сум нь адууны ям өвчний голомттой эсэх талаар мэдээлэл байхгүй. Тухайн айл нь адуу малладаггүй. 2018 оны 12-р сарын 25-нд чих хамар хоолойн эмчид үзүүлсэн. Тэр үед ханиад хүрээд 2 долоо хоносон. Хэд хоногийн өмнөөс булаг гарсан. Урьд нь бас гарч байсан. Эмчийн эмчилгээний үр дүн муу байгаа тул нян судалын шинжилгээ өгөх хүсэлт тавьсан. Одоогоор биеийн байдал тогтвортой байна. ЗӨСҮТ-ийн молекул биологийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн байна.

1.4 Мэрэгч амьтны сэжигтэй дуудлага:


Он гарсаар нийслэлийн БЗД-ээс мэрэгч амьтны 1 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжилгээ хийхээр хүлээн авав.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Олон улсад:

Шувууны томуу өвчин: Энэтхэг


Энэтхэг улсын ХААЯ-наас мэдээлснээр тус улсын Орисса хотын нэг бүс нутагт шувууны томуугийн H5N1 вируст халдварын дэгдэлт бүртгэгдэж 2500 шувууг устгаж, тус голомтод хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан тухай мэдээлжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин: Өмнөд Африк

Өмнөд Африк улсын ХААЯ-наас мэдээлснээр 01 дүгээр сарын 02-нд Лимпопо хотын Макхадо мужид “SAT 2” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдэж, 3600 үхэр өртөмхий байснаас, 2 үхэр өвчилсөн байна.



Эх сурвалж: ЗӨСҮТ

Хүний Коронавируст халдвар: Саудын Араб


Саудын Араб улсын ЭМЯ-ны мэдээлснээр 01 дүгээр сарын 07-нд хүний коронавируст халдварын 1 тохиолдол бүртгэгдсэн байна. Өвчтөн 33 настай, эрэгтэй. Саудын Араб улсын Рияд хотын Риядах мужид оршин суудаг. Одоогоор дэлхий дахинд 2012 оноос хойш хүний коронавируст халдварын 2283 тохиолд бүртгэгдэж, 806 нас баралт бүртгэгдээд байна.



Эх сурвалж: Promed

Гахайн сонгомол мялзан өвчин: Япон

Япон улсын Хөдөө аж ахуйн яамнаас 01-р сарын 09-нд мэдээлснээр Какамигахара хотын Гифү мужид 01-р сарын 05-нд гахайн сонгомол мялзан өвчнөөр 1 зэрлэг гахай өвчилсэн үхсэн байна.



Эх сурвалж: ЗӨСҮТ

Эбола вируст халдвар: Бүгд Найрамдах Ардчилсан Конго

БНАКУ-д 01 дүгээр сарын 04-ны өдрийн байдлаар Хойд Киву, Итури мужийн 16 ЭМТ-өөс эбола вируст халдварын сэжигтэй 609 (561 батлагдсан, 48 болзошгүй) тохиолдол, үүнээс 370 нас баралт бүртгэгдсэн.

